



МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

СОЁМБО МЭДЭЭ

№174 /384/ 2022.09.29

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Тусгай дугаар

Мэндчилгээ



“СОЁМБО” РЕДАКЦЫН ДАРГА, ЕРӨНХИЙ РЕДАКТОР ХУРАНДАА С.ТӨМӨРХУЯГ

Өдгөөгийн БХЯ-ны харьяа “Соёмбо” редакцын тулгийн чулууг тавилцаж, оюун ухаан юугаа уншигч олны мэдлэг мэдээллийн орон зайг дүүргэхэд зориулсан хүндэт буурлууд, залуу хойч үеийнхээ нөмөр нөөлөг, өмөг түшиг нь болсон эрхэм ахмадууд Та бүхэндээ “Олон улсын Ахмадын өдөр”-ийн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Та бүхний шанг нь татаж залуу нас, хөдөлмөр зүтгэлээ шингээн өртөөлөн дамжуулж эдүгээд авчирсан “Улаан Од” буюу “Соёмбо” сонин 99 дэх намартайгаа учран золгож байна. Түүхийн энэхүү урт замыг туулахад ахмадууд Та бүхэн ачааны хүндийг үүрч, оюун юугаа шавхаж, нөр их хөдөлмөрөө зарцуулсныг баярын энэ өдөр хүндэтгэн онцолж байна.

Батлан хамгаалах салбарын хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтаар хангаж, Төрийн батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг нийт алба хаагчид төдийгүй нийгэмд шуурхай хүргэж, цэргийн албыг сурталчлах замаар хүүхэд, залуучуудыг эх оронч үзэл хүмүүжлээр төлөвшүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд 2021 оноос эхлэн “Соёмбо” сонин болон “Дуулга” студийг нэгтгэн “Соёмбо” редакц болгон өргөжүүлж, стратеги, хөтөлбөрийг нь баталснаар Батлан хамгаалах салбар болон Зэвсэгт хүчний хэмжээнд зохион байгуулагдсан ажил, арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг текст, зураг, дүрст хэлбэрээр цаасаар, цахимаар, телевиз, радиогоор дамжуулан салбарын нийт бие бүрэлдэхүүнд төдийгүй олон нийтэд өдөр тутам шуурхай хүргэж ажиллах нөхцөл бүрэлдсэн юм.

Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний түүхийг бичилцэж, он цагийн хэлхээсийг холбодог эрхэм чухал үүрэг хүлээсэн тус редакцын хамт олон өнөөдөр 10819 дэх дугаараа уншигч олондоо өргөн барьж байгааг дуулгахад таатай байна. Та бүхний гэрэлтүүлсэн зам мөрийг бид улам баяжуулан хөгжүүлж ирээдүйд өвлүүлэн уламжлах болно.

Их зохиолчийн бийр янтайгаас эхлэн буухиалсан хэзээд үл тасрах оюуны алтан “Соёмбо”-ын цацраг уншигч олноо мөнхөд гэрэлтүүлж байг ээ.

“СОЁМБО” РЕДАКЦЫН ХАМТ ОЛОН АХМАДУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Олон Улсын Ахмадын өдрийг тохиолдуулан Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт “Соёмбо” редакцын хамт олон ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлээ.

Энэ үеэр редакцын дарга, ерөнхий редактор хурандаа С.Төмөрхуяг өнгөрсөн хоёр жилд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, “Соёмбо” сонины 100 жилийн ойг угтаж хийсэн ажлууд, эл ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөний төслийг ахмадуудаа танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэн ахмадуудынхаа санал

санаачилгыг сонсов. Түүнчлэн ахмадуудын саналаар “Соёмбо” сонины 100 жилийн ойг зохион байгуулах комиссын дарга, гишүүдийг сонгох юм.

Анхлан 1924 онд “Ардын цэрэг” нэрээр уншигчидтайгаа учран золгож улмаар “Улаан цэргийн соёлын зам”, “Улаан Одон”, “Улаан од”, “Тусгаар тогтнол”, “Соёмбо” нэрээр хэвлэгдэж, үе үеийн цэрэг армийнхны дотнын нөхөр байж, тэднийг соён гэгээрүүлж, сурган хүмүүжүүлж ирлээ. Монгол Улсын түүхэнд тохиолдсон хүнд хэцүү шалгалт сорилтын нэг 1939 оны Халхын голын байлдаан, 1945

оны Чөлөөлөх дайны жилүүдэд дарийн утаа үнэрлэж явсан дайчин хэвлэл бол “Улаан од” сонин, түүнээс салбарласан “Эх орны төлөө” фронтын сонин юм. Хүнд хэцүү цагт фронтод нуувчаас нуувч дамжин уншигдаж, ардын цэргийн цог жавхааг бадрааж, байлдаанаас байлдаанд дайчдыг зоригжуулж, ялалтын дайчин тугийг мандуулалцахад жинтэй хувь нэмэр оруулсан тус редакц энх цагт ч бэх үзгээ хатаалгүй, туурга тусгаар эх орноо батлан хамгаалах, улс гэрээ засан төвхнүүлэхэд нийтлэлийн бодлогоо чиглүүлэн ажиллаж байна.

“СОЁМБО” ХҮРТЭЛХ МАНАЙ СОНИНЫ ТҮҮХИЙН ТОВЧООН

1924.2.5. “Ардын цэрэг” сонины анхны дугаар хэвлэгдэн гарчээ.

1929.3.3. “Ардын цэрэг” сонин “Монгол ардын “Улаан цэргийн соёлын зам” нэртэй болов.

1930.9.6. “Улаан одон” нэртэй болж 7 хоногт хоёр удаа дөрвөн нүүрээр гарч эхлэв.

1938 оноос. Улсын болон цэргийн баяр, хэрийн сургуулийн үеэр “Маневрын улаан одон” нэртэй сониныг эрхлэн гаргаж байжээ.

1939. 6 дугаар сар. “Улаан одон” сониноос салбарласан “Эх орны төлөө” сонин 130 гаруй хоногт Халхын голын байлдааны фронт дээр 80 дугаар гаргасан байна.

1941 он. “Ухуулагч”, “Цэргийн бодлого”, “Байлдааны бэлтгэлийн төлөө” сэтгүүлүүд гарч байгаад 1950-иад онд тасалдав.

1944. 5 дугаар сар. “Улаан од” хэмээн нэрээ өөрчилж 20 жилийн ойгоороо Засгийн газрын Хүндэт үнэмлэхээр

1970. “Байлдааны бэлтгэл”, “Ардын арми” сэтгүүл гарч эхлээд 1991 оноос зогссон.

1974.2.4. “Улаан од” сониныг 50 жилийн ойгоор нь Сүхбаатарын одонгоор шагнажээ.

1978.11.24. “Ардын арми” сэтгүүлийг Байлдааны гавьяаны одонгоор шагнав.

1990.11.7. Цэргийн төв хэвлэл “Тусгаар тогтнол” нэртэй гарч эхлэв. 1991 оны 4 дүгээр сарын 30-нд БХЯ-ны сайдын тушаалаар сонины нэрийг баталсан юм.

1997.4.30. Батлан хамгаалахын сайдын тушаалаар Зэвсэгт хүчний “Тусгаар тогтнол”, Хилийн цэргийн “Эх орны манаа” сонины редакцуудыг татан буулгаж Бүх цэргийн “Соёмбо” сониныг гаргах болжээ.

2001.3.10. Сургалт, онол арга зүйн өдөр тутмын “Цэргийн шинэчлэл” сэтгүүлийн анхны дугаар хэвлэгдэв.

2001. 7 дугаар сар. Чөлөөт сэтгэлгээ, чөлөөт цагийн



шагнуулсан төр засгаас хүртсэн анхны шагнал байлаа.

1945. 8 дугаар сараас. “Эх орны төлөө” сонин Хилийн цэргийн “Эх орны манаа” нэртэйгээр гарч эхлэв.

1949 он. “Улаан од” сониныг 25 жилийн ойгоор нь Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнажээ.

1950.10.16. “Эх орны манаа” сониныг 10 жилийн ойгоор нь Байлдааны гавьяаны одонгоор шагнасан юм.

1953. 6 дугаар сар. “Эх орны манаа” сониныг “Улаан од” сонинтой нэгтгэжээ.

гаргаж эхэллээ.

2006.7 дугаар сар. Сонины редакц бууриа сэлгэж Офицеруудын ордонд байрлах болов.

2019.1.31. “Your time” хавсралт дугаарыг гаргаж эхлэв.

2016.12 дугаар сар “Соёмбо” сонин БХЯ-ны ТУЗГ-ын харьяанд шилжив.

2021.11 сар “Соёмбо” сонин болон “Дуулга” студийг нэгтгэх шийдвэр гарч “Соёмбо” редакц болон өргөжив.

2021.3.3 сараас Өдөр тутмын цахим сониныг гаргаж эхлэв.

“Нэмэх, хасах”

хавсралт

сонин 14 хоног тутам

МАНАЙ АХМАДУУД ЯРЬЖ БАЙНА

ЦЭРГИЙН СОНИН МИНИЙ ХОЁР ДАХЬ ГЭР

ЦЭРГИЙН СЭТГҮҮЛЧДИЙГ ТҮВШИН ӨНДӨР ХҮМҮҮС ГЭЖ БОДДОГ

МЗЭ-ийн шагналт, зохиолч, сэтгүүлч, бэлтгэлд байгаа дэд хурандаа Г.БААТАРНУМ:

-Их зохиолч Д.Нацагдорж, бичгийн хүн Н.Жадамба нарын галыг нь бадраасан "Улаан од" буюу өдгөөгийн "Соёмбо" сонин нь үе үеийн цэрэг дайчдыг хүмүүжүүлсэн үзэл суртлын хүчирхэг зэвсэг билээ. Ийм сайхан сонинтой нэгэн насны амьдралынхаа нэгээхэн хэсгийг холбох анхны үүд хаалга нь 40 гаруй жилийн тэртээ ЦЕДС-д суралцаж байх үеэс эхтэй юм. Тэр л он жилүүдэд анхны мэдээ материалаа бичиж байсан нь намайг сонин хэвлэлийн ажилтай амьдралаа холбох ирээдүйн замыг шулуутгаж өгсний зэрэгцээ 2001 оноос үндсэн ажилтан нь болсон хувь заяандаа бахархаж явдаг даа.

Өнгөрсөн хугацаанд хурандаа Б.Чинбат, М.Намсрай, Г.Нямдорж нарын тулхтай эрхлэгч нар, сэтгүүлч, яруу найрагч П.Батнайрамдал, залуу сэтгүүлч дэд хурандаа Х.Ганзул, хошууч Д.Мэндбаяр, ахлах дэслэгч А.Алтанхуяг нарын чадварлаг сэтгүүлч нартай хамт ажиллаж байснаараа ямагт бахархдаг. Энэ сонинд ажилласан 10 гаруй жилийн хугацаанд уран бүтээлд маань илүү ахиц гарч, "Цэргийн сэтгүүлчид" номыг эмхэтгэн хэвлүүлж, сонинхоо 90 жилийн ойгоор "Дарийн утаа үнэрлэсэн дайчин сонин" дуу зохиосон зэрэг аль баяр, амжилтыг бичиж барах вэ. Цэргийн сонингоо би бээр хоёр дахь гэрээ гэж сэтгэлдээ ямагт дээдэлж явдаг юм даа.



Бичиг хэргийн эрхлэгч-бичээчээр ажиллаж байсан Я.ЦЭГМИД:

-1973 онд Ж.Ядмаа хурандааг эрхлэгчээр ажиллаж байхад "Улаан од" сониндоо Бичээч-бичиг хэргийн эрхлэгчээр ажилд орж байлаа. Амьдралын минь сонирхолтой, дурсамжтай, оюунлаг арав гаруй жил энэ сонинтой холбоотой. Долоо хоногт гурван удаа гардаг, асар өндөр захиалгатай, уншигч олонтой сонин байсан болохоор үйлдвэрлэл тасралтгүй өрнөдөг байлаа. Хэдийгээр хамт олноосоо салах, холдох дургүй байсан ч цэргийн хүн болох хүсэлдээ дийлдэн Ардын Армийн 162 дугаар анги руу алба хаахаар явсан. Гэсэн ч сэтгэл татуу явсаар энэ сонингоосоо өндөр насны

тэтгэвэрт суусан болохоор өнөөдөр ахмадуудтайгаа уулзаж, хөөрөлдөөд сэтгэл маш өндөр байна. Энэ дундаа би бараг ахмад нь байх шиг байна шүү.

Цэргийн сэтгүүлчид гэдэг боловсролтой, соёлтой, ер нь л түвшин өндөр хүмүүс гэж боддог байлаа. Миний хань ЗХУ-д дээд сургууль төгссөн инженер хүн байсан. Сонингоос цэргийн анги руу явахад минь их л дургүй байсан даа. Энд ажиллаж байхдаа маш их зүйл сурсан, сурсан бүхэн минь амьдралын туршид их л хэрэг болж байлаа. Ц.Гаваа, Б.Чантуу, Пүрэвдорж нар маань манай ерөөгөөр их орж ирнэ. Цай буцалгах зуур маш их сонирхолтой юм ярина, түүнийг нь сонсох их дуртай байлаа.

ЭНЭ ТҮҮХЭН СОНИНЫ НЭГ ХЭСЭГ БАЙСНААРАА БАХАРХДАГ



"Соёмбо" сонин эрхлэгч асан, бэлтгэл хурандаа Х.ШАГДАР:

-Өнгөрсөн түүх, залуу насаа дурсахдаа бид залуужиж байдаг. Манай сонин урт түүхийн замналтай. Монголын бусад хэвлэлүүдтэй харьцуулахад эх орон болоод ард түмнээ хамгаалахын төлөө хоёр удаагийн дайнд оролцож цэрэг дайчдаада сэтгэлийн дэм, итгэлийн цог нь болж явсан энэ нэр хүндтэй байгууллагад ажиллаж явсан миний хувьд үнэхээрийн том хувь тохиол байсан гэж боддог. Аливаа хэвлэл мэдээллийн байгууллага ямагт нийгмийн урд нь гишгэх ёстой. Манай сонин хамт олон ч мөн адил тэр үүргээ өнөөг хүртэл биелүүлж байна. Хойч үеийн залуучууддаа захихад энэ үүргээ тасралтгүй биелүүлж, цаашид улам хөгжүүлж байгаарай гэдгийг хэлмээр байна. Миний бие "Улаан-Од" сонинтой 1979 онд анх холбогдож байлаа. Хожим буюу 2005, 2006 оны хооронд тус сонин эрхлэгчээр ажиллаж байснаараа бахархдаг. Ер нь бол сонинхоо цэвэрлэгчээс бусдыг хийж үзсэн. Хэвлэх үйлдвэр дээрээ олон ч шөнө хоносон. Сонинхоо цаасыг нөмрөөд л унтчихдаг байлаа. Одоо бодоход энэ бол бидний галтай, цогтой залуу үеийн хөдөлмөр зүтгэлийн илрэл байж дээ гэж бодогдож байна.

